



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2016 оны 6 сарын 30 өдөр

Дугаар A-161

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Төгрөг, юанийн своп хэлцлийн журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
- 2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 572 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төгрөг, юанийн своп хэлцлийн журам”-ыг хүчингүй болгосугай.
- 3.Энэ тушаалыг 2016 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Зах зээлийн газар (Ж.Батаа), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.
- 4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЗОЛЖАРГАЛ



14 1128

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны

6. дугаар сарын 20 нь өдрийн №:16/

дугаар тушаалтын хавсралт

ТӨГРӨГ, ЮАНИЙН СВОП ХЭЛЦЛИЙН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Банкуудын Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид БНХАУ гэх)-ын юаниар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Монголбанкнаас арилжааны банкуудтай төгрөг, юанийн своп хэлцэл (цаашид “своп хэлцэл” гэх)-ийг байгуулахад баримтлах зарчим, талуудын эрх, үүргийг тодорхойлоход энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Монголбанк своп хэлцлийг зөвхөн банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй банктай байгуулна.
- 1.3. Банк нь своп хэлцлээр худалдан авах юанийг зөвхөн Монгол Улс болон БНХАУ хоорондын гадаад худалдааг санхүүжүүлэх, юанийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, Монголбанкнаас зөвшөөрсөн бусад зориулалтын дагуу ашиглаж болно.
- 1.4. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.4.1. “Своп хэлцэл” гэж эхний гүйлгээгээр Монголбанк банкинд юань худалдаж, төгрөг худалдан авч, хугацааны эцэст Монголбанк төгрөгийг хүүгийн хамт банкинд эргүүлэн төлөх, банк юанийг хүүгийн хамт Монголбанкинд эргүүлэн төлөх нөхцөлтэй хэлцлийг,
 - 1.4.2. “SHIBOR” гэж Шанхайн банк хоорондын захын хүүг тус тус ойлгоно.

ХОЁР. Своп хэлцлийн үндсэн нөхцөл

- 2.1. Своп хэлцлийн тооцоолол нь ACT/365 хоногт суурилна.
- 2.2. Своп хэлцлийн хугацаа нь 1 жил буюу хуанлийн 365 хоног хүртэл хугацаатай байна.
- 2.3. Банкуудын своп хэлцлийн саналыг биелүүлэхдээ дуудлага худалдааны зарчмаар буюу банкуудаас ирүүлсэн төгрөгийн эх үүсвэрийн хүүгийн саналыг жагсаан хамгийн бага хүүгийн санал өгсөн банкны саналаас эхэлж хэлцлийг биелүүлнэ.
- 2.4. Своп хэлцлийн төгрөгийн эх үүсвэрийн хүүний доод хязгаар нь Монголбанкны овернайт хадгаламжийн хүү, дээд хязгаар нь бодлогын хүү байна.
- 2.5. Юанийн эх үүсвэрийн хүү нь своп хэлцлийн хугацаанд харгалзах SHIBOR хүүгээс 1.5 нэгж хувиар өндөр байна.
- 2.6. Тухайн өдрийн своп хэлцэл байгуулах саналын нийт дүн Монголбанкны байгуулах хэлцлийн нийт дүнгээс хэтэрсэн тохиолдолд хамгийн өндөр биелэгдэх хүү дээр ирсэн санал бүрийг уг хүү дээр ирүүлсэн нийт саналд харьцуулж тооцсон харьцаагаар Монголбанк своп хэлцлийг байгуулна.
- 2.7. Энэ журмын хоёрдугаар хавсралтад заасны дагуу своп хэлцлийн спот ханшийг тооцоолно.
- 2.8. Төгрөгөөр илэрхийлэгдсэн мөнгөн дүн нь төгрөг, мөнгө гэсэн бүтэцтэй байна.
- 2.9. Банк своп хэлцлийн хоёр дахь гүйлгээг нийтээр тэмдэглэх баярын болон долоо хоногийн амралтын өдөр таарахгүй байхаар Монголбанкинд саналаа өгнө.

ГУРАВ. Своп хэлцэл байгуулах журам

- 3.1. Банк нь своп хэлцэл байгуулах саналаа энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу Мягмар, Пүрэв гарагийн (уг өдөр нь нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол өмнөх ажлын өдөр) 09:30-10:00 цагийн хооронд “Гадаад валютын цахим арилжааны систем” (цаашид “арилжааны систем” гэх)-ээр дамжуулан Монголбанкинд хүргүүлнэ.
- 3.2. Зах зээлийн газар (цаашид ЗЗГ гэх) нь своп хэлцлийн саналыг судалж, биелсэн хэлцлийг тухайн өдрийн 15:00 цагаас өмнө Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх)-т хүргүүлнэ.
- 3.3. Монголбанк нь своп хэлцлийн биелсэн саналуудын төлбөр тооцоог санал биелсэн өдрөөс ажлын 2 өдрийн дараа хийнэ.
- 3.4. ТТБГ нь своп хэлцлийн төлбөр тооцоог гүйлгээ хийгдэх өдөртөө багтаан гүйцэтгэнэ.
- 3.5. Банк нь своп хэлцлийн эхний болон буцах гүйлгээ хийгдэх үед шаардлагатай төгрөг болон юанийг Монголбанк дахь харилцах дансандаа хүрэлцэхүйц хэмжээгээр төвлөрүүлсэн байна.
- 3.6. Монголбанк хугацааны эцэст банкнаас төлбөрийн даалгавар ирсэн эсэхээс үл хамаарч юань, төгрөгийн буцах гүйлгээг хийнэ.
- 3.7. Давагдашгүй хүчин зүйл болон цахим арилжааны сүлжээнд эвдрэл гарсны улмаас своп хэлцлийн саналыг арилжааны системд 09:30-10:00 цагийн хооронд хүлээн авах боломжгүй бол дараах үйл ажиллагааг явуулна:
 - 3.7.1. Монголбанк своп хэлцлийн санал авах хугацааг сунгаж болно. Энэ тухайгаа банкуудад 09:50 цагаас өмнө арилжааны системээр эсвэл утсаар мэдэгдэнэ.
 - 3.7.2. Монголбанк энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу банкуудаас своп хэлцлийн саналыг бичгээр хүлээн авна. Монголбанкны эдийн засагч нь банкны саналын битүүмж, лацыг шалгаж, банкны ажилтантай энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу баримт үйлдэнэ. Монголбанк битүүмжлээгүй саналыг хүлээн авахгүй.
- 3.8. ЗЗГ нь банкуутдай своп хэлцлийг байгуулна.
- 3.9. Монголбанк нь банк тус бүртэй байгуулсан своп хэлцлийн нөхцөлтэй холбоотой мэдээ, мэдээллийг нууцална.
- 3.10. Монголбанк нь своп хэлцлийн нэгдсэн мэдээллийг “Гадаад валютын дуудлага худалдааны журам”-ын дагуу өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
- 3.11. Банкууд своп хэлцлийн саналаа энэ журмын 3.7.2-т заасны дагуу ирүүлэх тохиолдолд саналыг банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамгаар баталгаажуулсан байна.
- 3.12. Банкны гарын үсгийн баталгаа, цахим шуудангийн хаяг өөрчлөгдсөн тохиолдолд санал авахаас ажлын нэг өдрийн өмнө Монголбанкинд бичгээр мэдэгдэнэ.
- 3.13. Монголбанк энэ журмын 3.1-д заасны дагуу банкны ирүүлсэн хэлцэл хийх саналыг эцсийн гэж үзэх бөгөөд банк нь уг саналаас татгалзах эрхгүй.

ДӨРӨВ. Банкинд тавих шаардлага

- 4.1. Банк нь своп хэлцлийн санал ирүүлэхдээ дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 4.1.1. Банк нь юанийн харилцах дансыг Монголбанкинд нээсэн байх
 - 4.1.2. Гадаад валютын зохицой харьцааны тайланг ам.доллар, юань тус бүрээр, своп хэлцлийн дуудлага худалдаа болохоос ажлын нэг өдрийн өмнөх байдлаар гарган Монголбанкинд тухайн ажлын өдрийн 10:00 цагаас өмнө хүргүүлсэн байх.
 - 4.1.3. Энэ журмын нэгдүгээр хавсралтыг бүрэн, үнэн зөв бөглөж, санал авах өдрийн 10:00 цагаас өмнө “Гадаад валютын цахим арилжааны систем” эсвэл бичгээр ирүүлсэн байх

ТАВ. Хариуцлага

- 5.1. Энэ журмын аливаа заалтыг эхний удаа зөрчсөн тохиолдолд Монголбанкны улсын байцаагч банкинд мэдэгдэл хүргүүлж, Банкны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авч хариуцлага хүлээлгэнэ. Банкинд ногдуулах торгуулийг тухайн банкны Монголбанкны харилцах данснаас үл маргах журмаар хасалт хийнэ.
- 5.2. Банк энэ журмын аливаа заалтыг давтан зөрчсөн тохиолдолд Банкны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авч хариуцлага хүлээлгэхээс гадна тухайн банкны гадаад валютын дуудлага худалдаанд оролцох найман удаагийн эрхийг хасна.
- 5.3. Банк нь удаа дараа энэ журмын заалтыг зөрчвөл Монголбанк тухайн банкны юанийн своп хэлцэл байгуулах үйл ажиллагаанд оролцох эрхийг бүрмөсөн хасна.
- 5.4. Банк нь энэ журмын 3.6 дахь заалтыг зөрчвөл энэ журмын 5.1-д зааснаас гадна хугацаа хэтэрсэн өдөр тутам тухайн банкны санал болгосон юанийн хүү дээр 5.0 (таван) хувийг нэмсэнтэй тэнцүү хэмжээний торгууль ногдуулан Монголбанкин дахь харилцах данснаас үл маргах журмаар хасалт хийнэ.
- 5.5. Банк нь своп хэлцлийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд Монголбанкин дахь нийт харилцах дансны үлдэгдэл хүрэлцэхгүй тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 730 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Своп, форвард хэлцлийн ерөнхий гэрээнд заасны дагуу хариуцлага тооцно.

_____оОо_____

“Төгрөг, юанийн своп хэлцлийн журам”-ын
нэгдүгээр хавсралт

СВОП ХЭЛЦЛИЙН САНАЛЫН МАЯГТ

Хэлцэл байгуулах огноо: ... оны ... сарын ... өдөр
Гүйлгээ хийгдэх огноо: ... оны ... сарын ... өдөр

1. Банкны нэр:
2. Хугацаа: хоног
3. Худалдан авах юанийн хэмжээ
4. Хэмжээ тоогоор, (үсгээр)
5. Төгрөгийн эх үүсвэрийн хүү


БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, Овог, нэр)

(Гарын үсэг)

(ТАМГА)


Бэлтгэсэн: (Мэдээлэл бэлтгэсэн ажилтны овог, нэр, албан тушаал)

Утас: (Мэдээлэл бэлтгэсэн ажилтантай холбоо барих утасны дугаар)

“Төгрөг, юанийн своп хэлцлийн журам”-ын
хоёрдугаар хавсралт

СВОП ХЭЛЦЛИЙН СПОТ ХАНШ

$$Spot_{rate} = \frac{USD_{MNT}}{USD_{CNY}}$$

Энд:

$Spot_{rate}$
 USD_{MNT}

Своп хэлцэлд ашиглах төгрөгийн юаньтай харьцах спот ханш
Хэлцэл байгуулсан өдөр мөрдөгдөж буй Монголбанкнаас зарласан

USD_{CNY}

төгрөгийн ам.доллартай харьцах ханш
Хятадын гадаад валютын арилжааны системийн цахим хуудас
(<http://www.chinamoney.com.cn/en/index.html>) -нд хамгийн сүүлд
зарласан юанийн ам.доллартай харьцах ханш.

“Төгрөг, юаний своп хэлцлийн журам”-ын
гуравдугаар хавсралт

САНАЛ ХҮЛЭЭЛЦСЭН БАРИМТ

... оны ... сарын ... өдөр

1. Банкны нэр

Дугаар	Хүлээлгэн өгсөн ажилтны овог нэр, албан тушаал	Гарын үсэг	Хүлээн авсан Монголбанкны ажилтны гарын үсэг	Хүлээн авсан цаг
1				
2				
3				
4				
5				
6				
.....				